



ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛИЙН
ДАРГА Н.ЛҮНДЭНДОРЖ ТАНАА

**МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА**

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу, Засгийн газрын IV байр,
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

2014.04.17 № 01/30 ЧН/ТӨГ/2014/01/ГА

Гэрээний үүргийн гүйцэтгэлийг
хангуулах тухай


Монгол Улсын Ерөнхий Аудиторт УАГ-аас 2014 онд нийлүүлэх бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөөг үндэслэн “Улсын төсвийн хөрөнгөөр 2013 онд хийсэн хөрөнгө оруулалтын хэрэгжилт, үр дүн”-гийн аудитаар тус байгууллагад улсын төсвөөс санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүнг шалгах явцад суудлын автомашин нийлүүлэхээр гэрээ байгуулсан гүйцэтгэгч гэрээнд заасан үүргээ бүрэн биелүүлээгүй зөрчил илэрлээ.

Худалдан авах ажиллагааны газар, Шүүхийн ерөнхий зөвлөл, “Дако” ХХК-ийн хамтарсан “Автомашин нийлүүлэх ажлыг гүйцэтгэх” 03/100 тоот гэрээг 2013 оны 7 дугаар сарын 09-ний өдөр “Тоёото Прадо-150” маркийн 30 автомашиныг (нэг бүрийн үнэ 76.0 сая) 2280.0 сая төгрөгөөр 8 дугаар сарын 25-ны дотор нийлүүлэхээр байгуулсан боловч “Дако” ХХК нь гэрээнд заасан хугацааг 75 хоногоор хэтрүүлж, 2013 оны 11 дүгээр сарын 05-ны өдөр “Тоёото Прадо-150” маркийн 26 автомашин хүлээлгэн өгчээ.

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 1.12-т “аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх...”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2009 оны 47 дугаар тушаалаар батлагдсан “Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 3.1.1-д “... алдаа зөрчлийг арилгуулахаар төрийн аудитын байгууллага холбогдох албан тушаалтанд албан шаардлага өгнө” гэсэн заалтыг үндэслэн доорх албан шаардлагыг өгч байна. Үүнд:

“Дако” ХХК-иас нийлүүлэгдээгүй байгаа “Тоёото Прадо-150” маркийн 4 автомашиныг хүлээн авах, эсвэл дээрх автомашины үнэ (4*76,0 сая) нийт 304,0 сая төгрөгийг 2014 оны 12 дугаар сарын 05-ны дотор буцаан авч, биелэлтийг Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Шүүхийн Ерөнхий зөвлөлийн дарга Н.Лүндэндорж, Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Л.Баяраа нарт даалгав.

АХЛАХ АУДИТОР
АУДИТОР



С.СЭРЧХОРОЛ
С.ОДОНЦЭЦЭГ